MWF

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

# МОНЭС 4

ЖИЛИЙН 2004 ТАЙЛАН

# ТАЛАРХАЛ

GLOBAL FUND FOR WOMEN

mama cash

ded Deutscher Entwicklungsdienst

GWOB

filia die frauenstiftung

VSO

UN Volunteers

THE SIGRID RAUSING TRUST

MWF

**Тайлан бэлтгэсэн:**
Н.Чинчулуун, Д.Пүрэвсүрэн, С.Цэрэнпүрэв, Б.Байгалмаа, Ч.Ундрах

**Орчуулсан:**
Б.Нандинчимэг

**Манай хаяг:**
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Бага тойруу, 44-р байр, 6 тоот

**Утас:** 330265
**Факс:** 976-11-317904
**Шуудангийн хайрцаг:** 280, Улаанбаатар-46А, Монгол улс.
**И-мэйл:** mones@magicnet.mn
**Вэб хуудас:** www.mones.org.mn

"Согоо нуур" ХХК-д хэвлэв

MWF

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

МОНЭС

# ЖИЛИЙН 2004 ТАЙЛАН

# Эрхэм зорилго

Эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн бүлгүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.

# Зорилт

- Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөний тогтвортой хөгжлийг хангахад туслах,
- Эмэгтэйчүүд, охидын хүний эрх, жендэрийн тэгш эрхийг баталгаатай хангахад хувь нэмрээ оруулах,
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, технологийн дэвшлийг нэвтрүүлэх,
- Хөдөөгийн эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг хөгжүүлэхэд туслах,
- Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх,

# АГУУЛГА


- МОНЭС-ийн Тэргүүний мэндчилгээ 5

**Нэг. Тэтгэлэг олгох хөтөлбөр**

- Тэтгэлэг олголт 2004 6
- Тэтгэлэгийн үр дүнгээс... 2003-2004 онд 8
- Гэнэтийн Тусламжийн Сан 12

**Хоёр. Сан бүрдүүлэх хөтөлбөр**

- Сан бүрдүүлэх кампанит ажил 15
- Дотоодын хандивлагчид 18
- Гадаадын хандивлагчид 21
- Хандивлагч байгууллагууд 21
- Ивээн тэтгэгч байгууллагууд 21

**Гурав. Гэгээрлийн хөтөлбөр**

- Нийгмийг өөрчлөх филантропи 23
- Үндэсний Сайн Дурынхны Сүлжээ 25

**Дөрөв. Байгууллагын чадавхи бэхжүүлэх хөтөлбөр**

- Бүтэц, зохион байгуулалт 25
- Иргэний нийгмийн оролцоо 27

**Тав: Санхүүгийн тайлан** 30

МОНЭС

*Монголын эмэгтэйчүүдийн хөгжил дэвшилийн төлөө сан бүрдүүлж тэтгэлэг олгоно.*



*ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ НИЙГЭМД ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ БАЙНА ГЭСЭН ҮГ.*

# Тэргүүний мэндчилгээ



*Ш.ЦЭВЭЛМАА*

*МОНЭС-ийн Тэргүүн,*
*Монгол Улсын*
*Анхны Тэргүүн хатагтай*

Монголын Эмэгтэйчүүдийн Сан үйл ажиллагааныхаа 4 жилийг ардаа орхилоо. Энэ хугацаанд бидний ажил жилээс жилд өргөжин тэлж улам арвин баялаг туршлагыг хуримтлуулж байна.

Хүнийг хайрлах, хүн хүндээ туслах гэдэг энэ ертөнцийн хүн зоны хамгийн сайхан мөн чанар билээ. Монголын эмэгтэйчүүдийн санд тусалж хандив өргөдөг хүмүүс бол нийгмийг өөдрөгөөр хардаг, сайн сайханд гэмүүллэг хүмүүс юм. Тэдний хандив, тусламжийг МОНЭС хүлээн авч нийгмийг өөрчлөхийн төлөө хүч хөдөлмөр, авьяас билгээ зориулж байгаа эмэгтэйчүүдийн бүлгүүдийн хөдөлмөрт зориулдаг. Тэдний үйл ажиллагаа нийгэмд зохих хувь нэмрээ оруулсан гэдэгт би эргэлзэхгүй байна.

Нийгмийг өөрчилнө гэдэг бол хөгжил юм. Хөгжихийн тулд хүмүүс хамтарч бүлэг болон хийж бүтээх хэрэгтэй. Яагаад гэвэл "олон хүний санаа оломгүй далай" гэдэг шүү дээ.

МОНЭС өнгөрсөн онд эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, охид, эмэгтэйчүүдийн хүний эрхийн асуудалд голлон анхаарч ажилладаг эмэгтэйчүүдийн ТББ болон бүлгүүдэд тусламж үзүүллээ.

2005 онд эмэгтэйчүүдийн анхан шатны үүсгэл санаачлагын бүлгүүдийн үйл ажиллагаанд илүү их анхаарч ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад зохих хувь нэмрээ оруулах болно.

МОНЭС-ийн хандивлагчид, ивээн тэтгэгчид, тэтгэлэг авагчид, сайн дурынхан болон эмэгтэйчүүдийг улам их амжилтанд хүргэхийн төлөө хичээн чармайж зүтгэж байгаа гүйцэтгэх албаныхандаа гүн талархал дэвшүүлье.

Монголын мянга мянган охид, эмэгтэйчүүд, эхчүүд аливаа бэрхшээл зовлонгүй амар амгалан, аз жаргал баяр хөөрөөр дүүрэн байхын ерөөл дэвшүүлье!

# НЭГ. ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

МОНЭС-ийн шалгуур үзүүлэлтийг үндэслэн эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүдээс ирсэн төслийн саналуудыг хүлээн авч жилд 2 удаа сонгон шалгаруулалт явуулдаг.

**2004 онд нийт 54 төсөл хүлээн авснаас 28 төсөлд 20 817 950 төгрөгийн тэтгэлэг олголоо.**

## Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр:

| Тэтгэлэг авсан байгууллагын нэр | Төслийн чиглэл | Тэтгэлэгийн дүн |
|---|---|---|
| Монголын Тахир Дутуу Эмэгтэйчүүдийн Холбоо | Байгууллагын чадавхийг бэхжүүлэх төсөл | 500 000 төг |
| "Бүсгүйчүүд 21 зуун" ТББ | Байгууллагын чадавхи бэхжүүлэх, тоног төхөөрөмж худалдан авах төсөл | 700 000 төг |
| Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах "ГҮНЖ" төв | Байгууллагын чадавхи бэхжүүлэх төсөл | 1 000 000 төг |
| "Бээжин+10" Ази, Номхон далайн орнуудын эмэгтэйчүүдийн ТББ-ын чуулга уулзалтанд оролцох | ХЭХДС, ЭЯГБХУТКХХҮСТ-ийн тус бүр 1 төлөөлөгчийн зардал | 1 522 950 төг |

## Эмэгтэйчүүдийн хүний эрх, жендэрийн тэгш эрхийг хангах чиглэлээр:

| Тэтгэлэг авсан байгууллагын нэр | Төслийн чиглэл | Тэтгэлэгийн дүн |
|---|---|---|
| Монголын Эмзэг Бүлгийн Ажил Хэрэгч Эмэгтэйчүүдийн Холбоо | Аслагдсан хорооллын хүүхдүүдэд зориулсан "Нүүдлийн сургалт"-нд зориулж канон олгох | 150 000 төг |
| ЭТББ-ын Эвсэл | Ажлын байрны бэлгийн дарамтлалын асуудлаар сургагч багш бэлтгэх сургалт | 800 000 төг |
| ЭЯГБХУТКХХҮСТ | "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эрх зүйн орчин Монголд" судалгааны ном хэвлүүлэх төсөл | 500 000 төг |
| ХЭҮТ-ийн салбар зөвлөл, Дархан-Уул аймаг | Охид эмэгтэйчүүдийн эсрэг ажлын байрны бэлгийн дарамтлалын талаарх сургалт, сурталчилгаа | 500 000 төг |
| Хүйсийн Тэгш Эрхийн Төв | "Бэлгийн хүчирхийлэл-хүчингийн гэмт хэргийн зохицуулалт Олон улсад" төсөл | 800 000 төг |
| "Салхич шувуун" ТББ | Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн талаар радио нэвтрүүлэг хийх "Гэгээн зүг" төсөл | 500 000 төг |
| "Глоб Арт" ТББ | "ОУ-ын Эмэгтэйчүүдийн Кино Форум зохион байгуулах" төсөл | 500 000 төг |
| ЭТББ-ын Эвсэл | Иргэний нийгмийн зүтгэлтэн Шилдэг эмэгтэйчүүдийг алдаршуулах төсөл | 500 000 төг |
| Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв /ХЭҮТ/ | "Манай гэр бүл" төсөл | 1000 000 төг |

**Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:**

| Тэтгэлэг авсан байгууллагын нэр | Төслийн чиглэл | Тэтгэлгийн дүн |
|---|---|---|
| Өвөрхангай аймгийн Хар хорин сумын Эмэгтэйчүүдийн Зөвлөл | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүдийн орхийн орлогыг нэмэгдүүлэх амьдрах ухааны сургалт | 954 000 төг |
| ХЭХДС, Хөвсгөл аймгийн Мөрөн сум /2 бүлэг/ | "Сүү шим" сургалт | 2 000 000 төг |
| ХЭХДС, Хөвсгөл аймгийн Хатгал сум /1 бүлэг/ | "Сүү шим" сургалт | 1 000 000 төг |
| ХЭХДС, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум | "Сүү шим" сургалт | 1 000 000 төг |
| Төв аймгийн Зуун мод хотын Эмэгтэйчүүдийн зөвлөл | "Гар хивс" төсөл | 926 000 төг |
| ЛЭОС-ийн Сэлэнгэ аймгийн Дулаанхан тосгон дахь салбар зөвлөл, | "Эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэх" жимсний чанамал хийх төсөл | 500 000 төг |
| ЛЭОС-ийн Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын салбар зөвлөл, | "Цаатан эмэгтэйчүүдийн гар урлал" төсөл | 1 156 000 төг |
| Монголын Эмзэг Бүлгийн Ажил Хэрэгч Эмэгтэйчүүдийн Холбооны Налайх дүүрэг дахь салбар зөвлөл | Эмзэг бүгийн эмэгтэйчүүдийг амьдрах ухааны сургалтанд хамруулж, орхийн орлогыг нэмэгдүүлэх" төсөл | 500 000 төг |
| Сүхбаатар дүүргийн эмэгтэйчүүдийн бүлэг | "Арвин ургац-алтан хандив" хүлэмж ажиллуулах төсөл | 272 000 төг |
| Ардчиллын Боловсролын Төв | ЧД-ийн 17-р хорооны 20 орхийг тарималжуулах, "Нэг яндан-нэг мод" төсөл | 482 000 төг |
| Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхчүүдийн Холбоо /ХБХЭЭХ/ | Хөгжлийн бэрхшээлтэй охидын "Тэнгэрлэг охид" клубыг дэмжих "Хийж сурцгаая" төсөл | 660 000 төг |
| Охид,залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах "ГҮНЖ" төв | "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүдийн орхийн орлогыг нэмэгдүүлэх" төсөл | 400 000 төг |

## МОНЭС нь төслийн уралдаан зарлаж тэтгэлэг олгодог

Нийгмийн хөгжил дэвшлийн төлөө өөрийн цаг зав, хөдөлмөр, хөрөнгө мөнгөө хандивлах, бусдыг хайрлах, тэтгэн туслах филантропи үзэл хандлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор төслийн уралдаан зарлаж дараах байгууллагуудад тэтгэлэг олгов.

- **Эмэгтэйчүүд хүүхэд хөгжлийн "Эх сан" төв** — **995 000 төг**
- **ЛЭОС** — **1 000 000 төг**

# 2004 онд олгосон тэтгэлэгийн үр дүнгээс...

**Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах "ГҮНЖ" төв**

***"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэйн улмаас ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй эхчүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх" төсөл***

***ХБ-тэй хүүхэдтэй эхчүүдийг сургалтанд хамруулах, түүхий эд худалдан авахад зориулж 400 000 төгрөгний тэтгэлэг авав.***



*Төсөлд хамрагдсан эх С. Ариунаа гэрээр нэхмэлийн хичээл заалгаж байгаа нь*




*Эхчүүд хийсэн бүтээлээрээ гар урлалын үзэсгэлэн худалдаанд 3 удаа оролцов.*

Судалгаанаас үзэхэд хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэйн улмаас байнга хөдөлмөр эрхлэх боломжгүй хүмүүсийн дийлэнх хувь нь өрх толгойлсон ганц бие эхчүүд байдаг. Тэд ихэнхдээ өрхийн тогтмол орлогогүй, амьдралын түвшин доогуур байдаг. Төсөлд ХБ-тэй хүүхэдтэй 6 эх хамрагдсан. Тэдний сарын өрхийн орлого нь хүүхдийн нь тахир дутуугийн тэтгэмж болох 18 000₮ төг юм. Төслийн хүрээнд эхчүүдийг хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь туслах зорилгоор нэхмэл, хатгамал, макриам хийх гар урлалын сургалт, сэтгэл санааг дээшлүүлэх, өөртөө итгэлтэй болгох "амжилтын алхам, сэтгэл засал" сургалтыг "Эх сан" төвтэй хамтын ажиллагааны гэрээний дагуу хийсэн. Эхчүүдийг сургалтанд хамруулахаас гадна бие дааж бизнес эхлэх боломж олгож эдгээр эхчүүдийн урласан бүтээгдэхүүнийг үзэсгэлэн худалдаанд оролцуулах, хувь хүмүүст борлуулах, бусдад таниулах зэргээр байнга хамтран дэмжиж ажиллаж байна. Эхчүүд сургалтанд хамрагдсанаар сэтгэл санаа нь дээшилж, өөртөө, маргаашдаа итгэх итгэлтэй, хүүхдээ асрахын хажуугаар жижиг үйлдвэрлэл эрхлэх, орлогоо тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх, нийгмийн амьдралд идэвхи санаачлагатай оролцох хүсэл эрмэлзэлтэй болоход нь тус дөхөм болсон.

---

**"Ардчиллын Боловсролын Төв"-ийн дэргэдэх V-club**

***"Нэг яндан-нэг мод"***

***"V" клубын сайн дурынханыг дэмжиж ЧД-ийн 17-р хорооны 20 өрх айлыг тарималжуулах, сургалт явуулах зардалд 480 000 төгрөгний тэтгэлэг олгов.***

ЧД-ийн 17 хорооны урьд өмнө нь хашаандаа мод тарьж байгаагүй, өрхийн хураамжаа цаг тухайд нь төлдөг, санаачлагатай 20 өрхийн насанд хүрсэн 74, 18 хүртэл насны 33, тэтгэврийн насны 12, үүнээс ажилтай 30, ажилгүй 20, нийт 107 хүнийг хамруулж, жимсний мод, бут суулгах замаар гэр хорооллын агаарын бохирдлыг багасгах буюу гэр хорооллын өнгө үзэмжийг сайжруулахыг зорьлоо. 107 иргэнийг сургалтанд хамруулж гарын авлага материалаар хангаснаас гадна, мөн мод тарих хүсэлтэй иргэдэд гарын авлага, зааварчилгаа тарааж, хэрэгцээтэй мэдээллийг урьдчилан өглөө. Сургалтын дараа 120 ширхэг жимсний мод, улиас, хайлаас, монос, үхрийн нүд, үрэл зэрэг жимсний бутаар жижиг хэмжээний цэцэрлэг үүсгэж, амьдрал ахуйдаа хэрэглээ болгох, эрүүл орчинд зөв амьдрах сэтгэлгээг хүмүүст төрүүлсэн нь төслийн гол үр дүн байлаа. Мод тарьсаны дараа айлуудын хашаа, хашаан доторхи эмх цэгц зэрэгт анхаарал, хяналт байнга тавьж байсан учраас төсөлд хамрагдсан айлуудын 40% нь хашаа хороондоо тавих анхаарал сайжирсан.







**"Глоб Арт" Төв**

***"Дэлхий ертөнц бүсгүйчүүдийн нүдээр"***

***Олон улсын Эмэгтэй киночдын II кино форумын дугуй ширээний ярилцлагын зардалд 500 000 төгрөгний тэтгэлэг олгов.***

Кино форумд Монгол, ОХУ, Украйн, Швед, Тажикстан, Афганистан зэрэг улсын эмэгтэй киночдын уран сайхны болон баримтат нийт 17 киноны үзлэг "Тэнгис" кино театрт болж давхардсан тоогоор 2000 гаруй хүн үзэж сонирхлоо. Форумын үеэр "Эмэгтэйчүүд кинонд" дугуй ширээний ярилцлага хийж нийт 36 хүн оролцон "Эмэгтэй киночид, шинэ мэргэжил үү, шинэ боломж уу, кино дахь эмэгтэйчүүдийн сэдэв, уламжлалт сэдэв үү, шинэ сэдэв үү?" гэсэн асуудал хөндсөн сэдвүүдээр харилцан ярилцаж өнөө үед кино дэлгэцийн урлагт эмэгтэйчүүдийн дүрийг хэрхэн гаргаж байна, хэрхэн гаргах ёстой, цаашид юунд анхаарах нь зүйтэй болохыг ярилцаж өөр өөрсдийн улс орны кино урлагт цаашид анхааран ажиллах тухайгаа ярилцаж санал солилцлоо.





*Кино форумын дугуй ширээний ярилцлагын үеэр*

---

**Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан /ЛЭОС/**

***"Филантропич гэж хэн бэ"***

***Филантропийн үзэл хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны зардалд 995 000 төгрөгний тэтгэлэг олгов.***



*Филантропийн талаар сургалт явуулж байгаа нь*

Олон нийтэд филантропийн үзэл хандлагыг төлөвшүүлэх, эмэгтэйчүүдийн хөгжлийн төлөө бодит үйл ажиллагаанд оролцогч сайн сайхны төлөө чармайн зүтгэгч байхын ач холбогдолыг ойлгуулах зорилготой хэрэгжсэн энэхүү төслийн хүрээнд сурталчилгааны олон талт ажлуудыг Улаанбаатар хот, Багануур дүүрэгт зохион байгууллаа. "Филантропийн сургалт" явуулах нөхцөлийг бүрдүүлсэн танхимын болон зайны сургалтын хөтөлбөрүүд боловсруулан зохих сургалтын материалын хамтаар нийт 21 аймгийн 190 сумын салбаруудад хүргүүлэв. Сурталчилгаанд филантропи агуулгатай зурагт хуудас, 2004 оны хуанли хэвлүүлэн ашиглав. Орон нутгаас ирүүлсэн урьдчилсан мэдээгээр нийт 4000 гаруй иргэдэд мэдээлэл түгээсэн байна.

**Эмэгтэйчүүд, хүүхэд хөгжлийн "ЭХ САН" төв**

***"Өгөөмөр сэтгэлээ бусдад зориулъя"***

***Филантропи хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны зардалд 1 сая төгрөгний тэтгэлэг олгов.***




*Улсын Их Дэлгүүр дээр явуулсан филантропи сурталчилгаа* 2004.05.15

Төслийн хүрээнд филантропийн үзэл хандлагыг дэлхийн чиг хандлагатай нийцүүлэн нийгмийн хөгжил дэвшлийн төлөө төлөвшүүлэх зорилго бүхий аян зохион байгуулагдлаа. Үүнд филантропийг сурталчилсан зурагт хуудас, энгэрийн тэмдэг хэвлүүлэн гаргаж Улсын Их Дэлгүүр, III, IV хороолол, Номин супер маркет, Кока Кола компани зэрэг газруудаар тарааж сурталчилгаа хийжээ. Филантропичуудын эгнээг өргөтгөх зорилгоор бизнесийн байгууллага, хувь хүн, гадаадын байгууллагуудын төлөөлөгчдийг оролцуулсан коктейль уулзалтуудыг зохион байгуулав. Нийтдээ 3000 гаруй иргэдэд филантропи сурталчилгаа, ЭТББ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээсэн болно.

---

**Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв /ХЭҮТ/**

***"Миний гэр бүл" төслийн эхний шат***

***4 насны ангиллаар нийт 20 000 ширхэг гарын авлага хэвлэх зардалд 1 000 000 төгрөг олгов.***




*4 насны ангиллаар хийсэн гарын авлагууд*

2004 оныг "Гэр бүлийн жил" болгон зарласантай холбогдуулан БСШУЯ, ХТҮГ, ХЭҮТ, ОУБС-аас санаачлан 2004-2005 оны хичээлийн жилд сургууль, хүүхдийн байгууллагууд хамтран "Гэр бүл дэх хүүхдийн аюулгүй байдлын төлөө, хүүхэд бүрийг гэр бүлийн хэвийн орчинд амьдарч хөгжихөд нь туслах" кампанит ажил өрнүүлж байгаа юм. Энэ хүрээнд хэд хэдэн ажил санаачлан хийхээр төлөвлөсний эхний шат нь **"Миний гэр бүл"** сэдэвт хичээлийг БСШУ-ны сайдын 272 тоот тушаалаар 2004 оны 9 сарын 1-нд улс даяар бүх сургууль, цэцэрлэгийн анги бүлгүүдэд ангийн багш нар заахаар зохион байгуулж заав. **"Миний гэр бүл"** сэдэвт хичээлийг хэрхэн явуулах талаар зөвлөмж бүхий гарын авлагыг цэцэрлэг, бага, дунд, ахлах ангийн багш нарт зориулж 4 төрлөөр боловсруулж 20 000 ширхэг хэвлэн гаргаж хүргүүлсэн байна. Энэ зөвлөмжид хичээлийн агуулгын талаар багшид зориулсан мэдээлэл, зөвлөгөө, үлгэрчилсэн конспект багтсан бөгөөд тухайн багш өөрөө заах аргаа сонгож хичээлийг зохион байгуулахаар тусгасан болно. Төслийн үр дүн 20 000 багш нар, нийт 800 000 гаруй хүүхдэд хүрэв.

# 2003 оны зарим төслийн үр дүнгээс...

**ЛЭОС-ын дэргэдэх "Залуу Лидер" Клуб**

***"Нарантуул ОУХТ-д үйлчилгээ эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхцөл" судалгаа***

***Нарантуул зах дээр хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхцөл, сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг сайжруулахад юуг анхаарах зэргийг судлах судалгааны зардалд 1 000 000 төгрөгний тэтгэлэг олгов.***




Баримт бичгийн судалгааны арга, стандарт сурвалжлага, анкетийн аргаар авсан энэхүү судалгаанд Нарантуул зах дээр гадна, дотор лангуу болон павильон түрээслэгч, явуулын худалдаа эрхлэгч, үйлчилгээний ажилтан нийт 270 эмэгтэй хамрагдсан. 6 бүлгээс бүрдэх судалгааны тайланд албан бус секторт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн нийгмийн бүтцэд эзлэх байр суурь, амьжиргааны түвшин, орлого, хөдөлмөрийн нөхцлийн талаархи ойлголт, түүнийг хэрхэн үнэлдэг байдал, учирч буй бэрхшээлүүд, түүнд хандаж байгаа хандлага, мөн Нарантуул захын удирдлагаас хөдөлмөрийн нөхцөл, зохион байгуулалт, эрүүл ахуйн орчинд хэрхэн анхаарч ямар арга хэмжээ авч байгаад судалгаанд оролцогчдын хандаж буй хандлагыг тодорхойлон багцалж гаргасан. Судалгааны эцэст Нарантуул зах дээр худалдаа арилжаа эрхлэгч эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхцөлийг хэрхэн сайжруулах ямар арга зам байна, хэрхэн нөлөөлж ямар ажил зохиох, юунд анхаарах зэрэг асуудлаар иргэдийн байр суурийг тусгасан зөвлөмж боловсруулан гаргалаа. Зөвлөмжийг зохих албан байгууллага, сонирхогч талуудад хүргүүлсэн ба цаашид нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах юм.

---

**Ходоогийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг Дэмжих Сангийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл**

***"Сүү шим"сургалт***

***Эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулах, сүүн бүтээгдэхүүн боловсруулах сургалт, бизнес эхлэх гарааны зардалд 1 500 000 төгрөгний тэтгэлэг олгов.***



*Хэвэнд оруулсан ааруул, ээдэм*

Төслийн хүрээнд 2 удаагийн сургалтаар 5 сумаас сонгогдон ирсэн 80 эмэгтэйчүүд орчин үеийн технологиор сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах аргачлалд суралцан сурсан зүйлсээрээ үзэсгэлэн худалдаа, амталгаа гаргаж олон нийтэд танилцуулав. Эхний сургалтын дараа "Цомог", Сүүн цацал, Торлон нэртэйгээр эмэгтэйчүүдийн 3 бүлэг байгуулагдан тус бүрдээ 500 000 төгрөгний тэтгэлэг авч ажилласан бөгөөд 6 сарын дараа Торлон бүлэг 400 000, Цомог бүлэг 363 000, Сүүн цацал бүлэг 441 200 төгрөгний цэвэр ашигтайгаар ажиллаж анх авсан 500 000 төгрөгний тэтгэлэгийг дараагийн сургалтаас байгуулагдсан эмэгтэйчүүдийн 3 бүлэгт тус бүр 500 000 төгрөг шилжүүлэн өгсөн байна. Цаашид эдгээр 3 бүлэг өөрсдийн олж авсан цэвэр ашгийн үндсэн дээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн явуулах боломжтой болсон бөгөөд жижиг худалдаа мөн эрхлэх төлөвтэй байна.

## Гэнэтийн тусламжийн сан

МОНЭС 2004 онд "Гэнэтийн тусламжийн сан" байгуулж тэтгэлэг олголоо. Тусламж дэмжлэг нэн шаардлагатай байгаа эмэгтэйчүүдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох зорилготой энэхүү тэтгэлэгийн хэмжээ нь **10 000-100 000Г** төгрөг юм. Бидний санаачлан хийсэн ном, гар урлалын бүтээгдэхүүн зэрэг эд зүйлсийн жижиг худалдаанаас олсон ашигаар тус тэтгэлэгийн мөнгийг бүрдүүлдэг бөгөөд өнгөрсөн онд нийтдээ **500 000** гаруй мянган төгрөгийг гэнэтийн тусламжийн санд бүрдүүлж, 12 эмэгтэйд **417 900** төгрөгний тусламж олголоо.

## Тэтгэлэгийн эдийн засгийн үзүүлэлт

| Үзүүлэлтүүд | 2001 | 2002 | 2003 | 2004 | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Эмэгтэйчүүдийн бүлгүүдээс хүлээж авсан төслийн тоо | 18 | 33 | 58 | 54 | **163** |
| Дэмжигдсэн | 12 | 21 | 26 | 28 | **87** |
| Дэмжигдээгүй | 6 | 12 | 32 | 26 | **76** |
| Тэтгэлэгт олгогдсон мөнгөн дүн /мян төг/ | 4134.0 | 7496.4 | 12273.2 | 20817.95 | **44721.55** |
| Тэтгэлэгт хамрагдсан хүний тоо | 1366 | 7413 | 14750 | - | - |
| Гэнэтийн тусламж олгосон хүний тоо | - | - | | 5 | 12 **17** |
| Гэнэтийн тусламж олгосон мөнгөн дүн | - | - | 36100 | 417900 | **451000** |
| Байршилаар/Хот | 9 | 7 | 13 | 19 | **48** |
| Хөдөө орон нутагт | 3 | 14 | 13 | 9 | **39** |

- *Хугацаа дуусаагүй*

## МОНЭС-ийн тэтгэлэг олгосон Эмэгтэйчүүдийн бүлгүүдийн тоо




## МОНЭС-ийн тэтгэлэг олгосон байдал (мянган.төг)



# НЭГ ХҮН ЭРГЭЖ ХАРААД **2** ХҮНД ТУСЛАВАЛ НИЙГЭМ ХУРДАН ХӨГЖИНӨ.

*Нэг хүний тус
Нөгөө хүний амьдралыг өөрчлөх
агуу их хүчтэй.*

Дэлхий ертөнц дээрх хамгийн
сайхан зүйл бол өглөг өгөх
*Хелэн Келлэр*

Сайн санааны үзүүрт тос
Буян үйлдвэл сайн явна

**Өглөг өгөх нь үүрэг хариуцлага биш зөвхөн зүрх сэтгэл л юм.
Жон Де Рокфеллер**

*Энэрэнгүй байхын тулд хүмүүн бай
Хүмүүн байхын тулд хандив өргө*

ТА БИДЭНД ХАНДИВ ӨРГӨ,
БИД НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ХУВЬ НЭМЭР ОРУУЛЪЯ.

*Тэнхлүүн үед тэмээгээр тусалснаас
Тэвдэж явах үед тэвнээр тусалсан нь дээр*

***Хүнд тусалснаа март
Хүнээр туслуулснаа бүү март***

**САЙН ХҮН НОХОРСОГ
CААР ХҮН АМИНСАГ**

# ХОЁР. САН БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монголын эмэгтэйчүүдийн бүлгүүдээс ирсэн санал санаачлагыг дэмжихийн тулд мөнгөн сан бүрдүүлэх нь манай сангийн гол үйл ажиллагаа юм.

**Бид өнгөрсөн онд дотоодын эх үүсвэрээс 7.2 сая төгрөг гадаадын эх үүсвэрээс 19.8 сая төгрөг нийтдээ 27.0 сая төгрөг тэтгэлэгийн сан бүрдүүллээ.**

Тэтгэлэгийн сан бүрдүүлэхийн тулд хувь хүмүүсээс хандив цуглуулах, жижиг худалдаа хийх, компанит ажлуудыг зохион байгуулж байна.

## САН БҮРДҮҮЛЭХ КАМПАНИТ АЖЛУУД

2004 онд Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/ сан бүрдүүлэх зорилготойгоор 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан.

### 2004.04.30 Сан бүрдүүлэх үдэшлэг

Үдэшлэгийн үеэр: урлагийн тоглолт, эмзэг бүлгийн эхчүүдийн урласан гар урлалын үзэсгэлэн худалдаа, сугалаат худалдаа, бооцоот тэмцээн, хөгжөөнт тоглоом, цэнгээнт хөтөлбөр зэрэг арга хэмжээнүүд явагсан. Үдэшлэгт 50 хүн оролцож 249.100 төгрөгний хандив цуглууллаа.



*Үдэшлэгийн үеэр*

## 2004.06.01 Сан бүрдүүлэх цэнгүүн

Эх үрсийн баярын өдрөөр **"...ААЛЬ ЦАЙ УУ ГЭЖ БАЙНА"** гэсэн өргөн цэнгүүн зохион байгууллаа. Өргөн цэнгүүнд манай соёл урлагийнхан өөрсдийн ая дуугаа өргөсөн юм. МОНЭС энэ арга хэмжээг угтаж байгууллагынхаа танилцуулга, сонин, сурталчилгааны плакатуудыг гудамж талбайд олон нийтийн газар өргөн тараалаа. Цэнгүүний үеэр МОНЭС-ийн болон тэтгэлэг авсан бүлгүүдийн үзэсгэлэн, эмэгтэйчүүдийн гар урлалын бүтээгдэхүүний сугалаат худалдааг зохион байгуулснаас гадна амьжиргааны түвшин доогуур амьдралтай 50 эмэгтэй, тэргэнцэртэй 5 эмэгтэйд тоглолтын билетийг үнэгүй өгч үзүүллээ. Өргөн цэнгүүнд 650 гаруй хүн, 400 гаруй хүүхэд үзэж сонирхлоо. Цэнгүүнээс нийт 1.000.000 төгрөгний хөрөнгө босгов.



*Өдөрлөгийн үйл ажиллагаанаас*

## 2004.08.25 Хөрөнгө босгох кампанит ажил

**"Нэг хүний тус нөгөө хүний амьдралыг өөрчлөх агуу их хүчтэй"** гэсэн уриан доор намрын хөрөнгө босгох кампанит ажлыг гудамжинд анх удаагаа зохион байгуулсан. Кампанит ажил нь 7 хоног үргэлжилсэн ба 3, 4-р хороолол, Үзэсгэлэн худалдааны өмнөх талбай, Нарантуул зах дээр болж өнгөрлөө. Кампанит ажлын үеэр МОНЭС-ийн танилцуулга, сонин, гарын авлага зэргийг тараасан бөгөөд ном, үзэг балны жижиг худалдаа явагдав. Уг кампанит ажлыг зохион байгуулахад Монголын Сайн Дурын Нийгэмлэг, НҮБ-ын Сайн Дурын Байгууллага гүн тусалцаа үзүүлэв. Нийтдээ 303.007 мянган төгрөгний сан бүрдүүлэв.



*Кампанит ажлын үеэр*

## 2004 онд хандивласан мөнгөн дүнгийн үзүүлэлтүүд




## 2004 оны хандивлагчдын тоон үзүүлэлт /төгрөгөөр/






**Хандивлагч С.Эрдэнэцэцэг** */"АНН ХХК"-ний Худалдаа Маркетингийн Албаны Захирал/*

Би Удирдлагийн Академид Нийгмийн Удирахуйн Магистрийн ангид сурч байхлаа эмзэг бүлгийн, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өнчин, орон гэргүй хүүхдүүдэд тулгарч буй бэрхшээлд сэтгэл зовниж, хамт суралцдаг найз нартайгаа хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг байгуулахсан, эмэгтэйчүүдэд ажлын байр бий болгохсон, бага ч болов туслахсан гэж олон талаар ярилцдаг байв.

Харин МОНЭС нь эмэгтэйчүүдийг ядуурлаас гаргах, ажлын байрыг нэмэгдүүлэх, орлоготой болоход нь туслах зорилготойгоор хандив цуглуулж байгаа нь үнэхээр хэрэгцээтэй, хүнлэг сайхан санагдсан. Бусдад туслана гэдэг өөртөө тусалж буй хэрэг. Би бусдын төлөө, шударга ажилладаг ийм байгууллага байгаад баярлаж явдаг бөгөөд цаашдаа ч хандив өргөнө гэж бодож байгаа. Мөн өөрийн найз нарыгаа ч энэхүү буянтай ажилд татан оролцуулах бодолтой байна.

## Дотоодын хандивлагчдын нэрс

| No | Нэр | Харьяалал |
|---|---|---|
| **А** | | |
| 1 | Агиймаа. Д | УБ |
| 2 | Адъяа. н | УБ |
| 3 | Азбилэг. н | УБ |
| 4 | Аззаяа. Д | УБ |
| 5 | Алимаа. Ц | УБ |
| 6 | Алтансарнай. Б | УБ |
| 7 | Алтмаа. н | УБ |
| 8 | Алтанцэцэг. н | УБ |
| 9 | Амартүвшин. Н | УБ |
| 10 | Амгаланбаатар. н | УБ |
| 11 | Амирлан. н | УБ |
| 12 | Анхбаяр. Д | УБ |
| 13 | Ангара. н | УБ |
| 14 | Анхзул. н | УБ |
| 15 | Ариунаа. Ж | Баянхонгор |
| 16 | Ариунаа. н | УБ |
| 17 | Ариунаа. Х | УБ |
| 18 | Ариунтөгс. Ц | УБ |
| 19 | Ариунжаргал. н | УБ |
| 20 | Ариун-Ундрал. Ц | УБ |
| 21 | Ачиймаа. н | УБ |
| 22 | Аюурзана. Ч | УБ |
| **Б** | | |
| 23 | Баасанжав.н | УБ |
| 24 | Баатар.н | УБ |
| 25 | Баатарчулуун. Г | УБ |
| 26 | Байгал. н | УБ |
| 27 | Байгалмаа. С | УБ |
| 28 | Байгалмаа. Б | УБ |
| 29 | Байгалмаа. П | УБ |
| 30 | Бадарч. Г | УБ |
| 31 | Бадамгэрэл. н | УБ |
| 32 | Бадамжунай. н | УБ |
| 33 | Бадамцэрэн. н | УБ |
| 34 | Бадмаа. н | УБ |
| 35 | Бадмаараг. н | УБ |
| 36 | Батболд. н | УБ |
| 37 | Батдэлгэр. н | УБ |
| 38 | Батзаяа. Н | УБ |
| 39 | Батзориг. н | УБ |
| 40 | Батжаргал. н | УБ |
| 41 | Батмөнх. н | УБ |
| 42 | Баттөмөр. Д | УБ |
| 43 | Баттулга. н | УБ |
| 44 | Батчулуун. Н | УБ |
| 45 | Батхишиг. н | УБ |
| 46 | Батцэцэг. Б | УБ |
| 47 | Батчимэг. н | УБ |
| 48 | Бат-Эгшиг. Я | УБ |
| 49 | Бат-Эрдэнэ. н | УБ |
| 50 | Баянбат. н | УБ |
| 51 | Баянзул. Б | УБ |
| 52 | Баянжаргал. н | УБ |
| 53 | Баяр. Б | УБ |
| 54 | Баярмаа. Г | УБ |
| 55 | Баярмаа. Л | УБ |
| 56 | Баярмаа. н | УБ |
| 57 | Баяртуяа. О | УБ |
| 58 | Бизьяасүрэн. н | УБ |
| 59 | Билэгзаяа. Н | УБ |
| 60 | Болдбаатар. н | УБ |
| 61 | Болормаа. н | УБ |
| 62 | Болормаа. Н | Хөвсгөл |
| 63 | Болороо. н | УБ |
| 64 | Боорчи. н | УБ |
| 65 | Будтуяа. Г | Дорнод |
| 66 | Булгаа. н | УБ |
| 67 | Булган. н | УБ |
| 68 | Булгантамир. н | УБ |
| 69 | Бунд-Очир. Д | УБ |
| 70 | Буурцаг. М | УБ |
| 71 | Буяндэлгэр. н | УБ |
| 72 | Буянжаргал. н | УБ |
| 73 | Буянхүү. С | УБ |
| 74 | Бүжинлхам. Ч | УБ |
| 75 | Бөхчулуун. Г | УБ |
| 76 | Бэхбат. Б | УБ |
| 77 | Бямбажав. Ц | Баян-Өлгий |
| 78 | Бямбадорж. н | УБ |
| 79 | Бямбасүрэн. Э | УБ |
| 80 | Бямбасүрэн. н | УБ |
| 81 | Бямбацогт. н | УБ |
| **Г** | | |
| 82 | Галсанжамц. н | УБ |
| 83 | Ганболд. н | УБ |
| 84 | Ганбүргэд. Л | УБ |
| 85 | Ганчимэг. О | УБ |
| 86 | Ганчимэг. Г | Ховд |
| 87 | Ганчулуун. Г | УБ |
| 88 | Гантулга. Г | УБ |
| 89 | Гансум. Г | УБ |
| 90 | Ганнум. Г | УБ |
| 91 | Ганпүрэв. Г | УБ |
| 92 | Ганцэцэг. н | УБ |
| 93 | Ган-Эрдэнэ. н | УБ |
| 94 | Гомбо. Г | УБ |
| 95 | Гүндэгмаа. Г | УБ |
| 96 | Гүнжидмаа. Г | УБ |
| 97 | Гэгээнбилэг. О | УБ |
| 98 | Гэрэлнямэ. н | УБ |
| 99 | Гэрэлчимэг. О | УБ |
| 100 | Гэрлээ. О | УБ |
| 101 | Гэрэлцацрал. Д | УБ |
| **Д** | | |
| 102 | Даваа. н | УБ |
| 103 | Даваадорж. н | УБ |
| 104 | Даваанямэ. н | УБ |

| | | |
|---|---|---|
| 105 | Даваасүрэн. С | УБ |
| 106 | Даваасүрэн. Г | УБ |
| 107 | Давааңэрэн. Т | УБ |
| 108 | Даваахүү. Т | Хөвсгөл |
| 109 | Дамжин. Н | УБ |
| 110 | Дарамбазар. н | УБ |
| 111 | Дашзэвэг. Г | Төв аймаг |
| 112 | Дашням. Ц | Налайх |
| 113 | Долгормаа. Ж | УБ |
| 114 | Долгоржав. Д | УБ |
| 115 | Долгорсүрэн. Ц | УБ |
| 116 | Должмаа. Д | УБ |
| 117 | Дондов. С | УБ |
| 118 | Доржпагва. н | УБ |
| 119 | Доржсүрэн. н | УБ |
| 120 | Дүгэр. н | УБ |
| 121 | Дэлгэрмаа. н | УБ |
| 122 | Дэмбэрэл. н | УБ |

**Е**

| | | |
|---|---|---|
| 123 | Есөнмөнх. М | УБ |
| 124 | Есөн-Эрдэнэ. н | УБ |

**Ж**

| | | |
|---|---|---|
| 125 | Жавзансүрэн. н | УБ |
| 126 | Жавхаа. н | УБ |
| 127 | Жавхлан. н | УБ |
| 128 | Жавхлан. Х | УБ |
| 129 | Жамьянгарав. н | УБ |
| 130 | Жавцандорж. Р | УБ |
| 131 | Жаргал. А | УБ |
| 132 | Жаргалмаа. н | УБ |
| 133 | Жаргалсайхан. н | УБ |
| 134 | Жаргалсүрэн. н | УБ |

**З**

| | | |
|---|---|---|
| 135 | Загдсүрэн. Г | УБ |
| 136 | Занаа. Ж | УБ |
| 137 | Золзаяа. Я | УБ |
| 138 | Золзаяа. н | УБ |
| 139 | Золжаргал. н | УБ |
| 140 | Золтуяа. Д | УБ |
| 141 | Зориг. А | УБ |

**И**

| | | |
|---|---|---|
| 142 | Итгэл. О | УБ |
| 143 | Ичинноров. Ч | УБ |
| 144 | Ичинхорлоо. н | УБ |
| 145 | Ичинхорлоо. Б | УБ |

**Л**

| | | |
|---|---|---|
| 146 | Лхагвасүрэн. Э | УБ |
| 147 | Лхагвасүрэн. Ц | УБ |
| 148 | Лхамаа. н | УБ |

**М**

| | | |
|---|---|---|
| 149 | Маам. н | УБ |
| 150 | Мандаасүрэн. Ж | УБ |
| 151 | Мандуул. н | УБ |
| 152 | Мандхай. М | УБ |
| 153 | Марал. У | УБ |
| 154 | Марта. н | УБ |
| 155 | Мөнгөнцэцэг. н | УБ |
| 156 | Мэндбаяр. О | УБ |
| 157 | Мөнхбат. Н | УБ |
| 158 | Мөнхжавхлан. н | УБ |
| 159 | Мөнхөө. Ч | УБ |
| 160 | Мөнхтуяа. н | УБ |
| 161 | Мөнхзаяа. н | УБ |
| 162 | Мөнх-Эрдэнэ. М | УБ |
| 163 | Мөнх-Эрдэнэ. н | УБ |
| 164 | Мягмар. Н | УБ |
| 165 | Мягмар. н | УБ |
| 166 | Мягмарсүрэн. Ж | УБ |
| 167 | Мягмарсүрэн. н | УБ |

**Н**

| | | |
|---|---|---|
| 168 | Назгуль. Х | Баян-Өлгий |
| 169 | Найдандорж. А | УБ |
| 170 | Намуулун. Б | УБ |
| 171 | Намуун. Б | УБ |
| 172 | Нансал. Т | Увс |
| 173 | Нансал. Н | Увс |
| 174 | Наран. Д | УБ |
| 175 | Наран. н | УБ |
| 176 | Наранбат. н | УБ |
| 177 | Нацагням. Ц | УБ |
| 178 | Нарангэрэл. Л | УБ |
| 179 | Нарангэрэл. Р | УБ |
| 180 | Наранцэцэг. Ц | УБ |
| 181 | Наранцэцэг. Б | УБ |
| 182 | Нарантуяа. Л | УБ |
| 183 | Наранчулуун. н | УБ |
| 184 | Нармандах. Б | УБ |
| 185 | Номин-Эрдэнэ. н | УБ |
| 186 | Номуунтуул. н | УБ |
| 187 | Норовбадам. н | УБ |
| 188 | Нэргүй. Д | УБ |
| 189 | Нэргүй. Ц | УБ |
| 190 | Нямсүрэн. н | УБ |

**О**

| | | |
|---|---|---|
| 191 | Одгэрэл. Р | УБ |
| 192 | Одгэрэл. н | УБ |
| 193 | Отгон. Ц | УБ |
| 194 | Отгонбаатар. н | УБ |
| 195 | Отгонбаяр. Д | УБ |
| 196 | Отгонзаяа. Д | УБ |
| 197 | Отгонзул. н | УБ |
| 198 | Отгонжаргал. н | УБ |
| 199 | Отгонхүү. н | УБ |
| 200 | Отгончимэг. н | УБ |
| 201 | Оргил. н | УБ |
| 202 | Оюун. Ц | Увс |
| 203 | Оюун. С | Увс |
| 204 | Оюун. Т | Өмнөговь |
| 205 | Оюун. н | УБ |
| 206 | Оюунаа. н | УБ |
| 207 | Оюунбилэг. н | УБ |
| 208 | Оюунгэрэл. Ш | УБ |
| 209 | Оюунгэрэл. н | УБ |